



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 471

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "ХХV.3.1 "Цахим аймаг" төслийн тоног төхөөрөмж "Дундговь" төслийн хүрээнд бий болсон, 16 нэрийн, нийт 990,908,250.00 (есөн зуун ерэн сая есөн зуун найман мянга хоёр зуун тавь) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Дундговь аймгийн өмчид буюу Орон нутгийн өмчийн газарт бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга С.Хулан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 16 ны өдрийн
471 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР "ХХV.3.1 "ЦАХИМ АЙМАГ" ТӨСЛИЙН
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ "ДУНДГОВЬ" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ
ДАГУУ ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт дүн (төгрөг)
1	Ухаалаг самбар	БНХАУ	15	8,871,880.00	133,078,200.00
2	Ширээний иж бүрэн компьютер	Сингапур	180	2,680,990.00	482,578,200.00
3	Дэлгэц	Сингапур	180	719,300.00	129,474,000.00
4	Сервер компьютер	Сингапур	15	6,239,900.00	93,598,500.00
5	24 inch monitor	Сингапур	15	765,710.00	11,485,650.00
6	Дотор камер	БНХАУ	90	216,140.00	19,452,600.00
7	Гадна хяналтын камер	БНХАУ	30	728,220.00	21,846,600.00
8	Хяналтын бичигч төхөөрөмж	БНХАУ	15	656,710.00	9,850,650.00
9	Хатуу диск	БНХАУ	15	214,190.00	3,212,850.00
10	Сүлжээний кабель	Сингапур	15	260,550.00	3,908,250.00
11	Access point	БНХАУ	15	489,140.00	7,337,100.00
12	Сүлжээний кабель	БНХАУ	15	266,220.00	3,993,300.00
13	Сүлжээний кабелийн толгой	БНХАУ	15	16,310.00	244,650.00
14	Сүлжээний толгой хавчигч бахь	БНХАУ	15	36,320.00	544,800.00
15	Мэргэжлийн дрон	БНХАУ	15	3,838,710.00	57,580,650.00
16	Хэвлэгч, хувилагч, сканнер	БНХАУ	15	848,150.00	12,722,250.00
	Нийт дүн		660	26,848,440.00 (хорин зургаан сая найман зуун дөчин найман мянга дөрвөн зуун дөч)	990,908,250.00 (есөн зуун ерэн сая есөн зуун найман мянга хоёр зуун тавь)